


14 04 26
20... оны ...-р сарын ... өдрийн Хувьцаа
эзэмшигчдийн ээлжит хурлын
06... тогтоолын...-р хавсралт



“ХАРХОРИН” ХУВЬЦААТ КОМПАНИ

МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү мэдээллийн үйл ажиллагааны журам /цаашид “журам” гэх/-ын зорилго нь “Хархорин” ХК /цаашид “компани” гэх/-ийн хувьцаа эзэмшигчид болон бусад этгээдэд компанийн талаарх үнэн зөв мэдээллийг тогтмол хүргэх, эдгээр мэдээллийг нийтэд хүргэх арга, хэрэгсэл, хариуцах албан тушаалтан зэргийг тогтоохоос гадна компани нь Монгол Улсын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон дүрэм журамд заасны дагуу нийтэд тараагдаагүй мэдээ, мэдээллийг нээлттэй болгох, хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийн удирдлагад оролцох эрхээ зохистойгоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд оршино.
- 1.2. Энэхүү журам нь Монгол Улсын хууль, тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журам, компанийн дүрэм болон компанийн дотоод дүрэм журамтай нийцсэн байна.
- 1.3. Журмыг компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид “ХЭХ” гэх/-аар хэлэлцэн батлах ба батлагдан гарсан үеэс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.4. Мэдээллийг нээлттэй, ил тод байдлыг хангахын тулд дараах зарчмыг мөрдлөг болгоно. Үүнд:
 - 1.4.1. Тогтмол байх,
 - 1.4.2. Цаг хугацаандаа байх,
 - 1.4.3. Компанийн хувьцаа эзэмшигчид болон сонирхогч бусад этгээдэд бүгдэд нь тэгш хүртээмжтэй байх,
 - 1.4.4. Үнэн зөв, тодорхой, ойлгомжтой байх,
 - 1.4.5. Агуулгын хувьд хоёрдмол санаагүй, бүрэн дүүрэн байх,
 - 1.4.6. Компанийн бизнесийн эрх ашиг, нээлттэй байх зарчим хоёрын зохистой тэнцвэрийг хангасан байх,
 - 1.4.7. Хувьцаа эзэмшигчид мэдвэл зохих өөрийн үйл ажиллагааны доголдол, дутагдлыг нууж хаахгүй байх,
 - 1.4.8. Бусад мэдээллийн нээлттэй, ил тод байх үндсэн зарчмууд,

Хоёр. МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛИЙГ ХҮРГЭХ

- 2.1. Компани нь Монгол Улсын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журамд заасан, компанийн нууцад хамаарахгүй, компани нь нийтэд мэдээлснээр ямар нэгэн хохиролгүй гэж үзсэн мэдээ, мэдээллийг мэдээлэх бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид “СЗХ” гэх/, Монголын Хөрөнгийн Бирж /цаашид “МХБ” гэх/ болон бусад эрх бүхий байгууллагад хууль, дүрэм журмаар хүргэхээр тогтоосон мэдээ, мэдээллийг заасан хугацаанд нь хүргүүлнэ.

- 2.2.Компани нь СЗХ-ны “Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн журам”-д заасны дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг холбогдох маягтын дагуу гарган СЗХ-д хүргүүлнэ.
- 2.3.Компани нь дор дурдсан мэдээллийг СЗХ, МХБ-д холбогдох маяг, загварын дагуу тогтоосон хугацаанд хүргүүлж байх ба нийтэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон өөрийн вэб хуудсаар дамжуулан мэдээлж болно. Үүнд:
- 2.3.1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын тухай болон тэдгээр нь өөрчлөгдсөн тухай мэдээлэл,
- 2.3.2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тухай мэдээлэл,
- 2.3.3. Нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдийн нэр,
- 2.3.4. Нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд өөрчлөгдсөн тухай мэдээлэл,
- 2.3.5. Компаний томоохон зээлдүүлэгч, харилцагчдын тухай мэдээлэл /тухайн зээлдүүлэгчээс авсан зээлийн хэмжээ болон тухайн харилцагчаас хүлээн авсан бараа материал, тухайн харилцагчид гийлүүлсэн бараа бүтээгдэхүүн зэргийн дүн нь компаний нийт борлуулалтын 10-аас дээш хувьтай тэнцүү бөгөөд тухайн харилцагчтай 2-оос дээш жил тогтмол хамтран ажиллаж байгаа бол томоохон зээлдүүлэгч, харилцагч гэж үзнэ/
- 2.3.6. Компанийн хараат, охин компанийн тухай мэдээлэл,
- 2.3.7. Компанийн нэр, ерөнхий захиргааны оршин байх газар өөрчлөгдсөн тухай мэдээлэл,
- 2.3.8. Компанийн салбар, төлөөлөгчийн газрын тухай мэдээлэл,
- 2.3.9. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд гарсан өөрчлөлтийн тухай мэдээлэл,
- 2.3.10. Компанийн аудиторыг сонгон гэрээ байгуулсан, өөрчилсөн,
- 2.3.11. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийн тухай,
- 2.3.12. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /дүрмийн сан/-г нэмэгдүүлэх, хорогдуулах төслийг ТУЗ баталсан,
- 2.3.13. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан тухай,
- 2.3.14. Их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг ТУЗ юмуу хуульд заасан тохиолдолд ХЭХ баталсан тухай,
- 2.3.15. Компанийн үл хөдлөх хөрөнгийн 10-ээс дээш хувийг худалдсан, барьцаалсан, ямар нэг хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл,
- 2.3.16. Компанийн үйл ажиллагаа, хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын үйлдэлтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэсэн, эсхүл тэдгээр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, хуулийн дагуу шийтгэгдсэн,
- 2.3.17. Компанийг хуульд заасан хэлбэрээр өөрчлөн байгуулах төслийг ТУЗ баталсан,
- 2.3.18. Нийтэд санал болгон шинээр болон нэмж үнэт цаас гаргах төслийг ТУЗ, ХЭХ-аар баталсан тухай мэдээлэл,
- 2.3.19. Компанийн санхүүгийн тайлан, хараат бус Аудитын дүгнэлт, тайлбар тодруулгын хамт,

- 2.3.20. Компанийн үл хөдлөх хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийлгэсэн тухай тайлан,
- 2.3.21. Компанийн борлуулалтын орлогын 10-аас дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, лицензийг худалдсан, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай,
- 2.3.22. Компанийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдэлийн тухай мэдээлэл,
- 2.3.23. Монгол улсын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон бусад мэдээ, мэдээлэл.
- 2.4. Кампанийн үйл ажиллагааны жилийн тайланд дараах мэдээллийг агуулсан байх ба үнэн бодит байна:
 - 2.4.1. Компанийн зорилго, үйл ажиллагааны стратеги,
 - 2.4.2. Санхүүгийн байдал ба үйл ажиллагааны үр дүн,
 - 2.4.3. Хувьцаа эзэмшигчдийн статус болон хувьцаа эзэмшигчид эрх, үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн талаарх статистик тоо баримт,
 - 2.4.4. Хөрөнгийн нэмэгдсэн байдал ба санхүүгийн жилд гарсан капиталжих зардал,
 - 2.4.5. Бизнесийн орчин ба эрсдлийн хүчин зүйлүүд,
 - 2.4.6. Компанийн удирдлагад ажиллагсадын талаарх мэдээлэл,
 - 2.4.7. ТУЗ-ийн дарга, гишүүд, хараат бус гишүүд, Хараат бус аудиторууд, рейтингийн байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын үнэлгээний тайлан,
 - 2.4.8. Мэдээллийг нээлттэй болгох талаар хууль, зохицуулах байгууллагын журмын дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн эсэх, хэрэгжүүлээгүй бол хүлээсэн хариуцлага,
 - 2.4.9. Ирэх онд Компанийн засаглалыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөө,
 - 2.4.10. Компанийн тухай хууль, Компанийн дүрмээр тус тайланд тусгахаар заасан болон ТУЗ-өөс тус тайланд тусгах шаардлагатай гэж үзсэн бусад мэдээ, мэдээлэл.
- 2.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчид нь дараах мэдээлэлтэй танилцах бүрэн эрхтэй:
 - 2.5.1. Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан,
 - 2.5.2. Жилийн санхүүгийн тайлангийн холбогдох тайлбар, тодруулга, аудитын байгууллагын дүгнэлтийн хамт,
 - 2.5.3. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухай үндэслэл,
 - 2.5.4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга,
 - 2.5.5. Ээлжит хурлаар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцэх бол нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, үндэслэл, тайлбарын хамт, компанийг өөрчлөн байгуулах асуудал хэлэлцэх бол өөрчлөн байгуулах хэлбэр, үндэслэл, өөрчлөн байгуулах журам, үүнтэй холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам зэргийг тусгасан өөрчлөн байгуулах төсөл, бусад холбогдох баримт бичиг,
 - 2.5.6. Хувьцаа гаргах асуудал хэлэлцэх бол түүний борлуулалтаас олсон орлогыг хэрхэн зарцуулах тухай танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо. Хувьцаа эзэмшигчид хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах дагуу эрхээ хэрэгжүүлэх журам.

2.5.7. Өрийн бичиг бусад үнэт цаас гаргах тухай асуудал хэлэлцэх бол түүний борлуулалтаас олсон орлогыг хэрхэн зарцуулах тухай танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо.

2.6. Компани хууль, зохицуулах байгууллагын журам болон компанийн дүрмээр тогтоосон мэдээллийг нээлттэй болгохоос гадна хувьцаа эзэмшигчдийн хүссэн мэдээллийг цаг тухайд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй ба хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр компанийн мэдээллийг гаргаж өгөх үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хүлээнэ.

Гурав. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

3.1. Монгол Улсын хууль тогтоомж, СЗХ-оос гаргасан журам, Компаний дүрэм болон энэхүү журмаар тогтоосон мэдээллийг нээлттэй болгохоос гадна хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр цаг тухайд нь саадгүй гаргаж өгнө.

3.2. Компаний нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг нэгдмэл сонирхолтой эзэмшиж байгаа этгээд нь компаний нягтлан бодох бүртгэлийн болон гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэлтэй холбоглох мэдээллийг авах эрхтэй байна. Нэгдмэл сонирхолтой этгээд нь энэ тухайгаа СЗХ-д мэдэгдэн тодорхойлолт авсан байна.

3.3. Мэдээлэл хүсч байгаа хувьцаа эзэмшигч хүсэлтээ өөрийн болон эцэг /эх/-ийн нэр, хаяг, шуудангийн болон электрон шуудангийн хаяг, холбоо барих утас, эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл, авахыг хүсэж байгаа мэдээлэл, мэдээлэл авах хэлбэр /бичлэн, бичгээр, электрон шуудангаар/ зэргийг заасан байна.

3.4. Уг хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор /мэдээлэл ач холбогдлоо алдахаар бол боломжит богино хугацаанд/ ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан мэдээллийг боломжит халбэрээр хүргүүлнэ.

3.5. Хувьцаа эзэмшигчийн хүссэн мэдээлэл нь хууль тогтоомж болон компаний дотоод дүрэм журмаар тогтоосон нээлттэй болгох мэдээллийн жагсаалтад багтаагүй бөгөөд компаний бизнесийн нууцал хамаарахаар мэдээлэл бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг тухайн мэдээллийг авах тухай хүсэлтээ ирүүлсэн этгээдэд хүргүүлнэ.

Дөрөв. ХЯНАЛТ

4.1. Мэдээллийг нээлттэй, ил тод болгох ажиллагааг Гүйцэтгэх удирдлага эрхлэн явуулах бөгөөд түүний ажиллагаанд ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь тогтмол хяналт тавьж ажиллана.

4.2. Мэдээллийг нээлттэй, ил тод болгохдоо нууц, дотоод мэдээллийг хууль бусаар, компанийн ашиг сонирхлын эсрэг ашиглах явдлаас Гүйцэтгэх удирдлага урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

Тав. ХАРИУЦЛАГА

- 5.1. Монгол Улсын Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, СЗХ болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам болон энэхүү журмыг зөрчсөн буруутай этгээд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

“ХАРХОРИН” ХУВЬЦААТ КОМПАНИ